

ТЕЛЕВИЗИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Т.Өнөрсайхан\*

\* МУИС, НШУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр, докторант

**Түлхүүр үг:** мэдээ, телевизийн мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хэл найруулга, сэтгүүлч, үзэгч

“Мэдээ тухайн цаг, газар нутагт болсон үйл явдлын баримт юм”<sup>1</sup>. Мэдээ нийгмийн амьдралын байдал, хөгжил хөдөлгөөн, түүнийг танин мэдэхэд асар өргөн үүргийг богино хугацаанд гүйцэтгэдэг бөгөөд үүнд мэдээний гол ач холбогдол, үнэ цэнэ оршдог. Телевизүүд улс орны эдийн засаг, нам, улс төрийн амьдрал, олон улсын хэмжээнд болж буй үйл явдлыг тусгасан мэдээ гаргаснаар ард түмний үзэл санаа, бодолд нөлөөлж, нийгэм, улс төр, иргэний идэвх үүргийг сэргээдэг. Тиймээс телевизийг мэдээллийн хөтөлбөрөөр нь дүгнэдэг. “Телевизийн мэдээллийн хөтөлбөр сүлд модны чимэглэл шиг байх ёстой”<sup>2</sup>. Энэ нь тухайн цаг, өдрийн дугаар нь аль болох олон төрөл, олон салбарыг хамарсан, баялаг бүтэц, сэдэв, арвин багтаамжтай байна гэсэн үг юм. Мэдээ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээсээ хамаарч бичлэгийн өвөрмөц арга барилыг сэтгүүлчээс шаарддаг. Сэтгүүл зүйн онолын үндсэн зарчмууд болох “5W&1H” (хэн, юу, хэзээ, хаана, яаж, яагаад) телевизийн мэдээ бэлтгэхэд хамгийн чухал

хөрс суурь нь болдог. Мэдээж мэдээ гэсэн төрөл зүйлд хамаарах үндсэн шаардлагууд ч телевизийн мэдээнд тавигдана. Үүнд:

- Үнэн бодитой байх,
- Шуурхай байх,
- Хүртээмжтэй байх,
- Товч тодорхой байх,
- Хэд хэдэн эх сурвалжаас мэдээлэл авсан байх,
- Үндсэн баримтуудыг оновчтой багтаасан байх,
- Гадаад үг хэллэг ороогүй байх,
- Идэвхтэй байх,
- Сэтгүүлчийн дүгнэлт, үзэл бодлоос зайлсхийсэн байх,
- Бичлэгийн хувьд сонирхолтой, үзэгчийн анхаарлыг татахуйц байх гэх зэрэг шаардлагыг хангасан байх учиртай.

Гэхдээ тогтмол хэвлэлтэй харьцуулахад телевизийн мэдээнд ялгарах хэд хэдэн онцлог бий. Телевизийн мэдээ зөвхөн ганцхан удаа үзэгдээд өнгөрдөг учраас үзэгч тэр бүр бүгдийг нь барьж авч ойлгох боломж хомс байдаг. Тиймээс мэдээлж байгаа үйл явдлыг дээрх зарчмын дагуу ойлгомжтой хялбао үгээр, товч тодорхой хүргэх нь мэдээллийн албаны сэтгүүлчийн ур чадварын гол үзүүлэлт юм. Телевизийн мэдээ сонсоход зориулагдсан, өөрөөр

хэлбэл нүдний хараанд биш, чихэнд зориулагдан бичигддэг. Учир нь үзэгч сонины мэдээ шиг телевизийн мэдээг дахин дахин уншиж, тогтоож суух боломжгүй юм. Энгийн ойлгомжтой хялбар байх гэдэг телевизийн мэдээний гол зарчим болно. "Бид ярихдаа ямар хялбараар ойлголцдог билээ. Телевизийн мэдээний хэл яг түүн шиг энгийн, хялбар байх ёстой"<sup>3</sup>. Жишээ нь:

*"Насанд хүрээгүй сургуулийн жаахан охиныг найз залуутайгаа хардан хоолойг нь боож, хогийн жалганд хаясан энэ хэрэг анхан шатны шүүхээс Хэрлэнчимэгт 20 жил хорих ял, түүний найз залуу Очбадрахад мөн 20 жил, хэргийг хамтран үйлдсэн гэх Гантуяа, Ганболд, Сарантуяа нар тус бүрд нь 17 жилийн хорих ял оноосон ч хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй байсан гэх үндэслэлээр Өршөөлийн тухай хуульд багтан өршөөгдөж, Отгонжаргал, Очмандах, Тэмүүжин нарыг гэм буруугүй гэж үзэж цагаатгасан."* (ТВ-5, "Цаг" хөтөлбөр, 2011.06.02.) гэсэн мэдээ телевизийн хөтөлбөрөөр явж байна. Энэ мэдээг үзэгч шууд ойлгох боломжгүй. Мэдээний эхэнд маш олон үйл явдлыг тоочиж өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүн ард үлдсэнээс шууд ойлгох боломжгүй болсон байна. Зүй нь: "Улсын дээд шүүх сэжигтэн Хэрлэнчимэг, түүний найз залуу Очбадрах нарын тус бүрийн 20 жилийн ялыг хэвээр үлдээлээ. Хэрлэнчимэг гурван жилийн өмнө насанд хүрээгүй Б-г найз залуутайгаа хардан амь насыг нь хөнөөсөн юм. Тэдэнтэй хамтран энэ хэргийг үйлдсэн гэх Гантуяа, Ганболд, Сарантуяа нар тухайн үед насанд хүрээгүй байсан учраас Өршөөлийн тухай хуульд хамрагдсан. Отгонжаргал, Очмандах, Тэмүүжин нарын хувьд өмнөх шатны шүүхээс гэм буруугүйг нь тогтоосон

юм" гэж бичвэл илүү ойлгомжтой болно.

Телевизийн мэдээ үйл явдлыг дүрсээр давхар дамжуулдаг учраас нүдэнд үзэгдтэл үйл явдлын дэс дарааллыг нэгд нэгэнгүй тайлбарлах албагүй. "Телевизийн мэдээ гэдэг сэтгүүлч дүрсээр дамжуулж үйл явдлыг үзэгчдэд тайлбарлан хүргэхийг хэлдэг"<sup>4</sup>. Сонины мэдээнээс ялгарах онцлог нь телевизийн мэдээ байнга одоо цаг дээр бичигддэг учраас үйл явдлын аль болох сонирхолтой хэсгийг сугалан авч, урт нуршсан тайлбаргүйгээр үзэгчдэд хялбараар хүргэх ёстой юм.

**Т**елевизийн мэдээг дунд түвшний үзэгчдэд зориулан бичдэг. Тиймээс сунжирсан урт нийлмэл үг, өгүүлбэрээс аль болох зайлсхийх нь чухал юм. Үг хэмнэх зарчмаар бичвэрийг боловсруулдаг. Нэг өгүүлбэрт арваас дээш үг орохоос зайлсхийх нь чухал юм. Нэг мэдээ дунджаар дүрс ярилцлагатайгаа нийлээд 20-120 секундээс дээшгүй байх ёстой. Мэдээ богино тусам мэдээллийн хөтөлбөрийн багтаамжийг нэмэгдүүлэх бөгөөд нөгөө талаар ямар ч сэдвийн агуулга хоёр минутанд бүрэн гарна. Жишээ нь:

*"Сүхбаатар дүүргийн Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, цагдаагийн хэлтсийн хамтарсан ажлын хэсэг тус дүүрэгт аттестачилал явуулжээ. Тус ажлыг Монгол Улсын "Архидан согтуурахтай тэмцэх тухай", "Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай", "Хүнсний тухай", "Ариун цэврийн тухай" хуулиуд болон "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан бөгөөд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу тус дүүрэгт*

согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ эрхэлдэг хүнсний бөөний төв, хүнсний дэлгүүр, нийтийн хоолны газрууд зэргийг шалгасан байна." (ТВ-5, "Цаг" хөтөлбөр, 2011.06.02.) Жирийн иргэдийн хувьд энэ олон хууль тогтоомжийг мэдэх боломжгүй. Тэгээд ч мэдээллийн хөтөлбөрт ингэж уйтгартай нуршуу бичсэнээс үзэгчдэд ойлгомжгүй, сонирхолгүй болжээ. Уг санаа нь сар бүрийн нэгний өдөр архи худалдахгүй байх хотын даргын шийдвэр гарсан, үүний хэрэгжилтийг шалгасан тухай мэдээ байгаа юм. Гэтэл гол санаагаар гаргалгүй олон байгууллага, хуулийн заалт дурдаад мэдээ дуусч байна. Зүй нь: "Сар бүрийн эхний өдөр архи худалдахгүй байх журам хотын дарга гаргасан. Үүнтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагынхан Сүхбаатар дүүрэг дэх хүнсний дэлгүүр, хоолны газруудад шалгалт хийлээ" гэж бичвэл илүү ойлгомжтой байх юм.

Ямар ч тохиолдолд гадаад үг хэрэглэхээс зайлсхий гэсэн зарчим телевизийн мэдээнд үйлчилдэг. Жишээ нь:

"Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог бий болгох зорилгоор шинжлэх ухааны парк, технологийн бирж, технологийн инкубатор байгуулах ажлыг хурдавчлах, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд бизнесийн салбарын оролцоог нэмэгдүүлэхийг хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжид онцолсон байлаа." ("City news" мэдээллийн хөтөлбөр, 2011.01.19.) Энэ

мэдээнд үндэсний шинэчлэлийн тогтолцоог бий болгохын тулд хэрхэн ажиллах талаар зөвлөмж гаргасан бололтой. Инноваци гэдэг үгийг үзэгч тэр бүр ойлгох эсэх тодорхойгүй, эргэлзээтэй учраас аль болох монгол орчуулгаар мэдээлэх нь зүйтэй юм.

Телевизийн мэдээнд хэлц үг, зүйр цэцэн үгсийг ашиглахыг зайлсхийх ёстой байдаг. Жишээ нь:

"Урт нэрт ужгирч, барцад бурзайв"

("Өдрийн сонин", 2011.05.18) гэсэн сонин нийтлэл байна. "Гол мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" хуулийг хэлэлцэж, батлахгүй удаж байна гэсэн утгатай нийтлэл. Сонин

«

*Телевизийн мэдээ үйл явдлыг дүрсээр давхар дамжуулдаг учраас нүдэнд үзэгдтэл үйл явдлын дэс дарааллыг нэгд нэгэнгүй тайлбарлах албагүй. Сонин мэдээгээс ялгарах онцлог нь телевизийн мэдээ байнга одоо цаг дээр бичигддэг учраас үйл явдлын аль болох сонирхолтой хэсгийг сугалан авч, урт нурусан тайлбаргүйгээр үзэгчдэд хялбараар хүргэх ёстой юм.*

»

хуудсанд олны анхаарлыг татаж, шууд нүдэнд тусч байгаа мэт боловч телевизийн мэдээнд лид хэлбэрээр уншвал ойлгомжгүй, араас нь үргэлжлэх мэдээ лидээ тайлбарласаар үндсэн мэдээллээ өгч чадалгүй ашиггүй мэдээ болж хувирна. Тиймээс телевизийн мэдээнд ямар нэгэн санааг шууд утгаар нь гаргахыг илүүд үздэг.

Телевизийн мэдээнд хэт олон тоо болон тооны нэр хэлэхээс зайлсхийдэг. "Үзэгч тооны машин биш. Тэд мэдээ үргэлжлэх богино хугацаанд олон тоо тогтоож чадахгүй"<sup>5</sup>. Жишээ нь:

"2008 оны 2-р улирлын статистикийн дүн мэдээгээр улсын хэмжээнд хүлээж авсан төлийн тоо өмнөх

жилийн мөн үеийнхтэй харьцуулвал 27,79 хувь, тэр дундаа адуун сүрэг 34,89 хувиар, тэмээн сүрэг 20,33 хувиар өсчээ" гэсэн бичвэр сонинд гарсан байхад уншигч ямар нэгэн саадгүйгээр мэдээллийг авч цааш үргэлжлүүлэн унших болно. Телевизийн мэдээлэл нэг л удаа уншигдаж өнгөрдөг учраас ийм олон тоог үзэгч хүлээж авч ойлгож амждаггүй байна. Тиймээс телевизийн мэдээнд "2008 оны 4-р улирлын статистик тоон мэдээ гарлаа. Малчид өмнөх жилийнхээс 28 орчим хувиар илүү төл бойжуулсан байна. Адуун сүрэг 35 орчим хувиар, тэмээн сүргийн тоо толгой 20 гаруй хувиар өсчээ" гэж бичиж болно. Олон нуршсан тооноос зайлсхийж телевизийн мэдээний хэлэнд тоог илэрхийлэх "таван бутархайн аргыг" (телевизийн сэтгүүлчдийн бутархай тоог хэрэглэхдээ хэлж заншсан хэлбэр) энд хэрэглэж болно. Жишээ нь:

"Аттестатчилалд бөөний худалдааны төв 2, минимаркет 46, супермаркет 13, хүнсний дэлгүүр 163, ресторан 114, кафе 47, нийт 440 цэг салбар хамрагдсаны дүнд худалдааны 134, нийтийн хоолны 165 аж ахуй нэгж хамрагдаж стандартын үзүүлэлтийн 90 хувиас дээш үнэлгээ авсан бол, стандартын шаардлага хангаагүй нийт 104 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 33 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг түр түдгэлзүүлж, тохижилт хийлгэх, иргэд, СӨХ-ийн удаа дараагийн гомдлын дагуу 2 рестораны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 3 рестораны зэрэглэлийг бууруулсан байна" (ТВ-5, "Цаг" хөтөлбөр, 2011.06.02.) Хэтэрхий олон тоо нуршсан энэ мэдээ чухам юу өгүүлэх гээд байгаа нь хүртэл тодорхойгүй болжээ. Бидний дээр дурдсан үг хэмнэх зарчим

алдагдаж, үзэгчдийг олон тооны дунд төөрөгдөхөд хүргэсэн байна. Зүй нь: "Хүнсний дэлгүүр, хоолны газруудад хийсэн шалгалтанд нийт 440 орчим аж ахуйн нэгж хамрагдсан. Тэднээс үйл ажиллагааны доголтой 104 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр холбогдох албадаас гаргалаа. Харин үйл ажиллагаагаа сайжруулна гэсэн амлалтайгаар 33 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар түдгэлзүүлж, тохижилт хийлгэхээр болсон байна" гэвэл илүү ойлгомжтой болно. Заримдаа баримт илүүдэх тохиолдол бий. Ашиггүй олон тоо үзэгчдийг төөрөгдөлд хүргэж байгаа учраас гол хэрэгцээтэй гэсэн тоо баримтаа дундаас нь сугалан авч гаргах нь зөв сонголт болдог.

Телевизийн мэдээг өгүүлэгдэхүүн-өгүүлэхүүн-тусагдахуун гэсэн зарчмаар бичдэг. Тэмдэг болон үйлт нэрийг аль болох цөөн хэрэглэх нь зүйтэй юм. Ямар нэгэн зүйлийг тоочиж тайлбарлаж, нэрлэж байгаа бол гурваас дээш нэр оруулах нь тийм зөв зүйтэй бичвэр биш юм. Хэтэрхий олон тоочсон нэр үзэгчдийг залхааж, эхэнд нь хүлээн авч байсан мэдээллээ мартагнуулж, үйл явдлын уялдаа холбоог алдагдуулахад хүргэдэг. Жишээ нь:

**“М**онгол Улсын төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19-р зүйлийн 19.4 дэх хэсэг, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 22-р зүйлийн 22.1.4 дэх заалт, "Зээлийн баталгааны дээд хэмжээг тогтоох тухай" Монгол Улсын Их хурлын 2011 оны 2-р сарын 10-ны өдрийн 14-р тогтоол, "Үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2011

оны 3-р сарын 16-ны өдрийн 85-р тогтоолыг тус тус үндэслэл болгон Монгол Улсын Хөгжлийн банканд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Сангийн сайд гаргах зээлийн баталгааны үндсэн нөхцлийг урьдчилан тохиролцох зорилгоор "Монгол Улсын Засгийн газрын баталгааны үндсэн нөхцлийг тохиролцох гэрээ"-г 2011 оны 4-р сарын 26-ны өдөр байгууллаа" (ТВ-5, "Цаг" хөтөлбөр, 2011.04.27.) Энэ мэдээг сонсоод чухам юу хэлэх гээд байгаа, юу болсон талаар ойлголт авч амжилгүй үзэгч шууд сувгаа солих, аль эсвэл анзаарч, ойлголгүй өнгөрөх магадал их юм. Хэтэрхий олон хууль, тогтоомж дурдаж, өгүүлбэрийн хялбар байх өгүүлэгдэхүүн-өгүүлэхүүн-тусагдахууны зарчим алдагджээ.

**А**суудалд ул суурьтай хандахгүйгээр дутуу дулимаг боловсруулж яаран мэдээлснээс олон нийтэд ташаа ойлголт өгч, улмаар нийгэмд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдол дээрх жишээнүүдэд цөөнгүй ажиглагдлаа. Шинээр олон телевиз нээгдэж байгаа нь нэг талаар телевизийн урлагт өрсөлдөөн бий болгож, үзэгчдийг сонголттой, мэдээллийг олон ургальч байдлаар хүргэх боломж олгож байгаа боловч нөгөө талаар сэтгүүлчдийн ур чадвар хангалтгүй, мэдлэг дутмаг байгаа нь ил байна. Тиймээс өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж, тэдний ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй байгаа юм.

#### Ишлэл

<sup>1</sup> Корконосенко С. Г. 2000. Основы творческой деятельности журналиста. СПб., с. 139.

<sup>2</sup> Дэлгэрцэцэг М. 2006. Телевиз. УБ., 20 дахь тал.

<sup>3</sup> Walsh M. 2009. The responsibilities of a chief editor. Training session. Bangkok, p. 44.

<sup>4</sup> Besse B., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. Paris, p. 15.

<sup>5</sup> Walsh M. 2009. The responsibilities of a chief editor. Training session. Bangkok, p. 46.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэлгэрцэцэг М. 2006. Телевиз. УБ.
2. Зулькафиль М. 2002. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал. УБ.
3. Сүхбаатар Ц. 2009. Монгол хэлний найруулга зүй. УБ.
4. Корконосенко С. Г. 2000. Основы творческой деятельности журналиста. СПб.
5. Прохоров Е. П. 1993. Введение в теорию журналистики. М.
6. Цвик В. Л., Назарова Я. В. 2002. Телевизионные новости России. М.
7. 2011. Asiavision coordinators meeting. Langkawi.
8. Besse B., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. Paris.
9. Walsh M. 2009. The responsibilities of a chief editor. Training session. Bangkok.

#### Abstract

The article discusses the analysis of Mongolian television news. With news broadcasted about political events, economy and international activities, public and communities get the concrete understanding and knowledge of society, politics and development of the country and attract their interest to be an active in social daily life. Reputation of TV stations is evaluated by news programs. News program for particular day should cover all fields of economy and events occurred in both home country and international level to broadcast to the common public. The different resources of public media require the specific working skill and ability from the journalists. There are 6 key questions (who, what, when, where, how, why) or 5W&1H principle for the preparation of news program. Establishment of new TV stations has created the opportunity for fair competition to access the information from multi resources, but TV should pay a close attention on educational background and speaking abilities of dictors and commentators as well journalists and capacity building is required for TV personnel for the purpose to qualify their skills and capacity.